

Амьгүй биеийн амьдрал

Б.Жадамба*^a, А.Цог –Очир^b, Р.Сарангэрэл^b, Л.Эрдэнэчимэг^b

^aМонгол Улсын Боловсролын Их Сургууль,
Боловсрол судлал, судалгааны төв

^bМонгол Улсын Боловсролын Их Сургууль,
Нийгэм Хүмүүнлэгийн Ухааны Сургууль, Монгол хэлний тэнхим

Хураангуй

Монголчуудын бүтээсэн ертөнцийн статик ба динамик талын хамгийн ерөнхий хос эхлэл, амь ухагдахуун, түүгээр дамжуулан хос эхлэлийн өрөөлийг олох арга зүй зэрэгт түшиглэн, хүмүүний амь амьдралын болон түүнийг залгуулагчдын бүтэц тогтолцоог тодруулан томъёолсонд уг ажлын амин чанар оршин буй болно. Амь амьдрал, түүнийг залгуулагчдын бүтэц тогтолцоо, томъёоллын үүднээс бид өнөөгийн амьдрахуйгаа шинжвээс тэр нь “амьгүй биеийн амьдрал”, “амьгүй амьдрал” болж хувирах гээд буй алдаа оноогоо оновчлон тодруулж, түүний шалтгаан, түүнийг засах арга замыг тодорхойлж өгсөн нь уг ажлын шинэлэг хийгээд онцлог тал болно. Эл ажлын санаа уншигч таны амь амьдралаа залгуулахад тань бага ч атугай дэм болно гэдэгт бид итгэлтэй байна.

Түлхүүр үг

Амь амьдрал, амь амьдралыг залгуулагч, үйл эрдэм, сэтгэл орон, цаг мөнгө, эд зүйл, үйл, эрдэм, орон, цаг, үйл, нэг

Удиртгал

Ертөнц /юм/ бол нэг бодгаль /нэг юм, нэг амь, нэг олон/ хийгээд бодгаль нэг /юм нэг, амь нэг, олон нэг/ болохыг ухаарч ухамсарлан, тэдгээрийг нийтэд нь бус, жишээ болгон нэгийг нь, тухайлбал, ХҮМҮҮН-ийг сонгон авч, шинжсээр амь буюу амьдрахуй ухааныг бүтээсэн зон олон бол нүүдэлч Монголчууд билээ. Тэдний бүтээсэн амь ухаан, түүний арга технологийг тэдгээрийн талаарх баримтын сан хөмрөг болох монгол хэлээр дамжуулан оновчилж, түүнийхээ үндсэн дээр уламжлал шинэчлэл хослон хөгжих жам ёсны үндэслэлийг тодорхойлж, олны хүртээл болгохыг зорьж бид энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсэн болно.

Уг ажлын үндсэн судлагдахуун нь сүүлийн үед бидний бүтээн туурвисан Монголчуудын хос эхлэлийн гүн ухаан, түүний хамгийн ерөнхий хос эхлэл болох “цаг” ба “тэнгэр”, түүний динамик тал болох “орон-цаг”, “тэнгэр газар” ухагдахуунууд, амь буюу амьдрахуйн ухаан зэргийн талаарх судалгааны ажлууд байлаа. Харин судалгааны арга зүй нь алив бүхний аминд нь түшиглэн түүний амин холбоотой өрөөлийг тодруулах, амин холбоонд нь асуудлыг, тухайлбал, амь амьдралыг авч үзэхүй зэрэг болно.

Судалгааны арга зүй

Амьдрахуй ухаан үүтгэн хөгжүүлэх арга зүйн үндсийн үндэс нь түүний амийг тодруулах явдал болно. Тэрхүү тодруулах ёстой амь бол үйл нэг¹ /тэг, эв/, үйл, нэг гурав (Жадамба, Алтангоо, Ганбаатар, 2016. х.10). Харин тэрхүү тодруулах ёстой амь бол ертөнцийн хамгийн ерөнхий хос эхлэлийн динамик /арга, хэрэглэл/ тал болох “цаг тэнгэр²”, статик /билиг,бие/ тал болох “тэнгэр газар³”-ыг (Жадамба, Жонни Балтзерсен, 2016. х.45) нэгсгэгч, амилуулагч болох орон - цаг³ /“цаг орон”, “орон-цаг”/, “цаг буюу түүний эзэн үйл⁴ /”үйл нэг”, “нэг үйл”/ юм (Жадамба, 2016. х.28). Энэ нь ертөнцийн хамгийн ерөнхий хос эхлэлийн амь, бас амины хамгийн ерөнхий хос эхлэл бол орон - цаг буюу үйл нэг. Ертөнцийн хамгийн ерөнхий хос эхлэлийн амины буюу амины хамгийн ерөнхий хос эхлэлийн арга ба билиг тал нь харгалзан орон-цаг ба үйл нэг. Ертөнцийн хамгийн ерөнхий амь бол орон –цаг /”цаг орон”-ы/ ба нэг үйл /”үйл нэг”-ийн/ нэгсэл нэгэн. Ертөнцийн ерөнхий амины хийгээд түүний хамгийн ерөнхий хос эхлэлийн арга тал болох орон –цагийн динамик тал нь орон тархсан цаг⁵,

¹үйл нэг – шүтэлцэн багцрахуй, харилцан нөхцөлдөхүй, эвлэлдэн нэгсэхүй.

²мөнх тэнгэр – Монголчуудын шүтэн итгэж зорьдог нэгэн болох хамгийн ерөнхий амь.

³орон – цаг нь динамик талаасаа бол “цаг орон” -г, статик талаасаа бол “орон цаг” –ийг төлөөлөгч ухагдахуун болно.

⁴үйл нь динамик талаасаа бол “үйл нэг”-ийг, статик талаасаа бол “нэг үйл”-ийг төлөөлөгч ухагдахуун юм.

⁵Цаашид уг ажилд цаг, орон, үйл, нэг гэдгийн дор харгалзан “орон тархсан цаг”-ийг, “цаг хурсан орон”-г, “нэг тархсан үйл”-ийг, “үйл

*Холбоо барих зохиогч: jadambaabadrakh@yahoo.com

статик тал нь цаг хурсан орон.

Харин билиг тал болох үйл нэгийн динамик тал нь нэг тархсан үйл, статик тал нь үйл хурсан нэг гэсэн үг.

Ертөнц нэг хийгээд бодгаль лугаа амь мөн нэг /нэг амь/ хийгээд бодгаль /бодгаль амь/ билээ. Бүх бодгаль ертөнц дотроос зөвхөн хүмүүн л ертөнцийн хамгийн ерөнхий амийг /нэг амийг/ бүрэн бүтнээр нь авч төрсөн нэгэн тул, өвөг дээдэс ертөнцийг түүгээр төлөөлүүлэн судалж өөрсдийн амь болон гүн ухаанаа бүтээсэн байдаг. Үүнээс, ертөнцийн хамгийн ерөнхий амь, амь ухаан гэдэг нь хүмүүний амь, амь ухаан. Ертөнцийн хамгийн ерөнхий амь, түүнийг судална гэдэг бол хүмүүний амь, түүний амийг /амьдралыг/ шинжихүй гэж тус тус үзэж болох байна. Амь нь статик талаасаа бол “орон –цаг” ба “нэг үйл” –ийн, динамик талаасаа бол “цаг орон”-ы ба “үйл нэг”-ийн нэгсэл нэгэн. “цаг орон” бол “цаг тэнгэр”-ийн газар орны төлөөлөл дэх дүр. Ертөнцийн хамгийн ерөнхий хос эхлэл болох “цаг тэнгэр” –ийн арга ба билиг тал нь харгалзан “цаг” ба “тэнгэр” юм. “цаг” ба “тэнгэр” ухагдахууны өрөөл нь юу болохыг амь буюу “үйл нэг” ухааны үүднээс тодруулж үзье.


Амь болох “үйл нэг” гэдэг бол “үйл үр” буюу “үйл үг”, нэг буюу үг. Тэгэхээр, алив ухагдахууны амин холбоотой өрөөлийг нь олохын тулд, юуны өмнө тэдгээртэй хоршдог, эсвэл “үйл үг”-ээр, “үг”-ээр холбогддог ухагдахууныг түүвэрлэн, тэдгээрээс хамгийн олон холбоос бүхий ухагдахууныг оновчлох шаардлагатай болдог. Оновчилсон ухагдахуун нь цаашид өрөөлтэйгээ хоршин амь бүтээж, өөрийнхөө семантик орны бусад үгийг амилуулж нэгийг буюу тэгийг бий болгож байвал түүнийг анхны ухагдахууны өрөөлд тооцож болдог. Энэ бол амь ухагдахууныг ашиглан, тухайн ухагдахууны амин холбоотой өрөөлийг тодорхойлох, тухайн амь ухааныг үүтгэн хөгжүүлэх арга зүй юм.

Судалгааны үр дүн

Бид энэхүү арга зүйн дагуу судалгаа хийн, ертөнцийн хамгийн ерөнхий хос эхлэл болох “цаг” ба “тэнгэр”-ийн амин холбоотой өрөөл нь харгалзан “мөнгө” (Цог –Очир, 2016. х-15-26) ба “сэтгэл” (Жадамба, Эрдэнэчулуун, 2012. х.31) болохыг тогтоосон билээ /Зураг 1/.

Зураг 1

Мөнгө цагийн, сэтгэл тэнгэрийн амин холбоотой өрөөл болох нь



хурсан нэг”-ийг тус тус ойлгож бичих болно.
 “Үйл үр” нь “үйл үр” – ийн гүн ухааны амь ухагдахуун лугаа адил “үйл үг” нь “үйл үг”-ийн буюу динамик гүн ухааны амь ухагдахуун болно.

Уг зургаас, мөнгө ба цаг нь зарцуулах, үрэх, тооцох ...гэх мэт, тэнгэр ба сэтгэл нь мэдэх, ивээх, хуйсагнах...гэх мэт “үйл”ээр, “үйл үг” -ээр холбогддог. Бас мөнгө ба цаг нь алга, байхгүй, их, бага... гэх мэт, тэнгэр ба сэтгэл нь агуу, зөв, сайхан... гэх мэт “үг” - ээр нийлэлцдэг. Мөнгө ба цаг, мөн тэнгэр ба сэтгэл нь хоёр атлаа нэгэн, нэгэн атлаа хоёр бөгөөд харилцан бие /статик, билиг/, хэрэглэл /динамик, арга/ болдог зүйлс. Мөнгө бол цаг. Цаг бол мөнгө. Тэнгэр бол сэтгэл. Сэтгэл бол тэнгэр. Нэгдүгээр зурагт үзүүлсэн үйл, үйл үг, үг бол мөнгө ба цагийн, тэнгэр ба сэтгэлийн амь. Мөнгө ба цаг нь “мөнгө - үйл/үйл үг, үг/ -цаг”, тэнгэр ба сэтгэл нь “тэнгэр - үйл/үйл үг, үг/ - сэтгэл” гэсэн “ахуй - амь - ухамсар” лугаа гурамсан буюу амин холбоотой гэж тус тус харагдаж байна.


Мөн тэнгэр газар, газар орон, тэнгэрийн орон, сэтгэлийн орон, тэнгэрийн цаг, сэтгэлийн

цаг, орон –цаг /орны цаг/ зэргээс, орон /цаг/ нь тэнгэр ба газрын, тэнгэр ба сэтгэлийн амь бөгөөд харгалзан “газар – орон /цаг/ –тэнгэр”, “тэнгэр – орон /цаг/ –сэтгэл” гэсэн амин холбоотой нь харагдаж байна. Иймд нэгдүгээр зургийн “(мөнгө – цаг) + (тэнгэр - сэтгэл)”-ийг “мөнгө - (цаг - орон) – сэтгэл” буюу “сэтгэл - (орон - цаг) – мөнгө” гэж үзэж болно.

Түүнчлэн, цаг ба сэтгэлийн амь нь орон. Орон ба мөнгөний амь нь цаг. Орон ба эрдмийн амь нь сэтгэл. Цаг ба эдийн амь нь мөнгө. Сэтгэл ба үйлийн амь нь үйл. Мөнгө ба нэгийн амь нь эд. Үйл ба нэгийн амь нь эрдэм. Эд ба үйлийн амь нь нэг билээ.

Энэ бүхнийг нэгтгэн, “орон –цаг” ба “нэг үйл”-ийн нэгсэл нэгэн болох амийг дараах байдлаар дүрсэлж болно.

Зураг 2
Хүмүүний амь амьдрал



Хүмүүний амь, амьдралын энэхүү зургийг мөн

⟨НЭГ|ҮЙЛ⟩⟨ҮЙЛ|ЭРДЭМ⟩⟨ЭРДЭМ|СЭТГЭЛ⟩⟨СЭТГЭЛ|ОРОН⟩⟨ОРОН|ЦАГ⟩⟨ЦАГ|МӨНГӨ⟩⟨МӨНГӨ|ЭД⟩⟨ЭД|НЭГ⟩

хэмээн томъёолж болно /томъёо 1/.

Хүмүүний амь амьдрал нь түүний амь /2 дугаар зургийн босоо тэнхлэг буюу хавтгай/ ба амьдралын /2 дугаар зургийн хэвтээ тэнхлэг буюу хавтгай/ нэгсэл нэгэн. Хүмүүний амь амьдрал болох уг нэгсэл нэгэнг залгуулагч нь “үйл эрдэм”, “сэтгэл орон”, “цаг мөнгө”, “эд зүйл” байна. /томъёо 1/.

Хүмүүн бүр өөр өөрийн орон - цагаараа амилж, орон - цагаараа амьдарч, орон - цагаараа амьдралын мөнх бусыг үздэг. Хүмүүн бүрийн тэрхүү орон - цагийг амилуулагч эзэн нь түүний “нэг үйл”. Нэг бол хүмүүний амин /мөн/ чанар. Үйл бол хүмүүний мөн чанарын өөрөө болсон

ёс. “Нэг үйл” нь хүмүүний амины эзэн бие /билиг/ тал бол, орон - цаг нь түүний хэрэглэл /арга/ тал. Орон - цагаа даган “нэг үйл” хөдлөнгө, “нэг үйл”-ээ түшин “орон –цаг” зогсох замаар хүмүүний амь тасралтгүй өөрчлөгдөж байдаг /2 дугаар зургийн босоо тэнхлэгийн дагуух үйлийн явц хийгээд ажиллагаа/.

Харин хүмүүний амьдрал нь хүн ёсны ба хууль журмын дагуух амьдралын нэгсэл нэгэн байна. Хүн ёсны амьдрал бол хүмүүний амины динамик /арга/ тал. Хууль журмын дагуух амьдрал бол хүмүүний амины статик /билиг/ тал. Хүмүүний амьдрал хүн ёсны амьдралаа даган хууль журмын дагуух амьдрал хөдөлж,

хууль журмын дагуух амьдралаа түшин хүн ёсны амьдрал зогсож байнга хувирч байдаг. Хүн ёсны амьдралын амин сүнс нь эрдэм ба сэтгэл бол, хууль журмын дагуух амьдралын амин сүнс нь эд ба мөнгө байна. Эрдэм ба эд, сэтгэл ба мөнгө, хүн ёсны амьдрал ба хууль журмын амьдрал нь хоёр атлаа нэгэн, нэгэн атлаа хоёр бөгөөд харилцан хэрэглэл, бие болдог зүйлс юм. Эрдэм нь эдийн, сэтгэл нь мөнгөний, хүн ёсны амьдрал нь хууль журмын дагуух амьдралын хэрэглэл бол, эд нь эрдмийн, мөнгө нь сэтгэлийн, хууль журмын дагуух амьдрал нь хүн ёсны амьдралын бие бөлгөө.

Эрдэм ба эдийн, сэтгэл ба мөнгөний, хүн ёсны ба хууль журмын дагуух амьдралын нийцэл /тохироо/ буюу төгс зохицол бол хүмүүний амьдралын амь, бас амьдралын чанар. Үүнээс, амьдралын амины амь хийгээд хэрэглэл тал нь эрдэм, сэтгэл, хүн ёсны амьдрал, харин бие тал нь эд, мөнгө, хууль журмын дагуух амьдрал гэж харагдаж байна.

Монголчууд “Эдээр биеэ чимэхээр эрдмээр биеэ чим”, “эрдэмгүй хүн таг, зөгүй хүн яг” хэмээн амьдралын амины амь талыг, тухайлбал, эрдмийг, сэтгэлийг буюу хүн ёсны амьдралыг дээдэлдэг уламжлалт соёлтой ард түмэн юм. Гэтэл өнөөдөр бид энэхүү уламжлалт соёлоо умартаж, амьдралын амины бие талыг, тодруулбал, эдийг, мөнгийг, хууль журмын амьдралыг дээдэлдэг болох гээд байна. Үүнийг л бид “амьгүй биеийн амьдрал”, “амьгүй амьдрал” гээд байгаа юм.

Мөн хоёрдугаар зургаас болон амь амьдралын дээрх томъёоллоос, амь амьдралыг залгуулагч нь харгалзан “үйл эрдэм”, “сэтгэл орон”, “цаг мөнгө”, “эд нэг” /”эд зүйл”/ байна. Эдгээрийн “үйл эрдэм” нь амь амьдралыг залгуулагчийн “аргын арга”, “сэтгэл орон” нь “аргын билиг”, “цаг мөнгө” нь “билгийн арга”, “эд зүйл” нь “билгийн билиг” тал юм. Алив хүмүүн амь амьдралаа залгуулахын тулд юуны өмнө түүний “аргын арга” болох “үйл эрдэм” –д буюу үйл ба эрдмийг зэрэг эрхлэхүйд, эрдмийг эрхлэхүйд суралцах хэрэгтэй байдаг. Өнөөгийн “амьгүй биеийн амьдрал” –тай, “амьгүй амьдрал” –тай болчих гээд байгаагийн шалтгаан нь бидний дийлэнх үйлийг эрхлээд эрдмийг эрхлэхүйг орхигдуулж буйд л оршин байна. Үүнээс гарах арга зам бол бид бүхэн үйл ба эрдмийг зэрэг эрхлэхүй болох эрдмийг эрхэлдэг болох явдал юм. Ингэж чадах аваас цаашид бидний амьдрал “амьтай биеийн амьдрал”, “амьтай амьдрал”, “хүн ёсны амьдрал” болж хувирч өөрчлөгдөх нь лавтай.

Дүгнэлт

Ертөнцийн, тухайлбал, хүмүүний амь тодруулах арга зүйд /зураг 1/ түшиглэн бүтээсэн амь амьдралын бүтэц тогтолцоо /зураг 2/ болон түүний томъёолол /томъёо 1/ зэргийг задлан шинжилж нэгтгэснийхээ үндсэн дээр бид дараах дүгнэлтийг хийж байна:

- Амь гэдэг бол тухайн хүмүүнд /ертөнцөд/ заяагдсан “орон – цаг” ба “нэг үйл”-ийн нэгсэл нэгэн төдийгүй үйл, бас эрдэм, бас сэтгэл, бас орон, бас цаг, бас мөнгө, бас эд, бас нэг зэрэг байна.
- Хүн ёсны ба хууль журмын дагуу амьдрахуйн нэгсэл нэгэнг, бас амины агшнуудын тасралтгүй цуврааны нэгдэц нэгэнг, бас амины хугацааг, бас амь ахуйг /экологийг/, тэдгээрийн талаарх баримтыг амьдрал гэнэ.
- Хүмүүний амь ба амьдралын нэгсэл нэгэнг түүний амь амьдрал гэдэг.
- Хүмүүний амь амьдралын амь буюу хэрэглэл нь хүн ёсны амьдрал, бас эрдэм, бас сэтгэл, харин түүний бие нь хууль ёсны амьдрал, бас эд, бас мөнгө байна.
- Хүмүүний амь амьдралын амийг шүтэж, түүнд итгэж, түүнд зорьж, амь амьдралаа залгуулдаг явдал бол Монголчуудын уламжлалт соёл.
- Хүмүүний амь амьдралын биеийг шүтэж, түүнд итгэж, түүнд зорьж амь амьдралаа залгуулахыг оролддог явдал бол өрөөлийн соёл бөгөөд бидний амьдрахуйг “амьгүй биеийн амьдрал”, “амьгүй амьдрал” болгох талтай байна.
- Уламжлал ба шинэчлэлийг хослуулан амь амьдралаа дэвжүүлэн дээшлүүлэх явдал нь өнөөгийн бидний хөгжлийн зорилгын амь байна.
- Бидний амь амьдралыг залгуулагчийн аргын арга тал нь “үйл эрдэм”, аргын билиг тал нь “сэтгэл орон”, билгийн арга тал нь “цаг мөнгө”, билгийн билиг тал нь “эд зүйл” байна.
- Өнөөгийн “амьгүй биеийн амьдрал”-д, “амьгүй амьдрал”-д хүрэх гээд байгаагийн үндсэн шалтгаан нь бидний олонх үйлийг буюу бизнесийг эрхлээд, эрдмийг буюу ёс суртахууныг эрхлэхүйг орхигдуулж буйд оршин байна. Үүнээс гарах арга зам нь бид бултаараа үйл ба эрдмийг зэрэг эрхэлдэг буюу эрдмийг эрхэлдэг, эрдэмд суралцдаг болох явдал байна.

Ном зүй

- Жадамба, Б., Алтангоо, О., Ганбаатар, Т., (2016). Амьдрахуй ухаан. Улаанбаатар, Битпресс.
- Жадамба, Б. (2016). Үйлийн судалгааны квант. Улаанбаатар, Мөнхийн үсэг.
- Жадамба, Б., Жонни Балтзерсен. (2016). *Мэдээлэл*. Улаанбаатар: Битпресс.
- Жадамба, Б., Эрдэнэчулуун, Д. (2012). Психология кочевников - монголов один из вариантов концепций. *Сборник доклады конференций на тему "Перспективы развития образовательного пространство стран АТР и вызовы времени*. Иркутск,
- Цог - Очир, А. (2016). Зүйрлэлийн танин мэдэхүйн онол. *Монгол судлалын чуулган №21\56*. Улаанбаатар. Жиком Пресс.

Becoming lifeless, disembodied

*Jadamba.B^{*a}, Tsog-Ochir.A^b, Sarangerel.R^b, Erdenechimeg.L^b*

^aHead of research center of educational, School of educational studies, Mongolian National University of Education.

^bDepartment of Mongolian Linguistics, School of Humanities and Social Sciences, Mongolian National University of Education.

Abstract

The significance of this work lies in the fact that Mongolians, basing their reasoning on the general static and dynamic state of the universe, consciousness of life, and through these the method of finding this double-origin state, have identified and named the arrangement of human life, and the essentials thereof.

If we study life from the standpoint of this arrangement of life, its essentials, and the terminology used to describe it, we see that it is becoming lifeless, disembodied. The uniqueness of this treatise lies in its new attempt to identify and describe the points at which this is occurring, the reason for this change, and in prescribing a plan for remedying the situation.

We hope that the ideas presented in this paper will be of some help to you, the reader, in discovering the essentials of life.

Keywords

Life, arrangement of life, act and knowledge, time and money, soul and space, things, act, knowledge, space, time, act, one

* Corresponding author: jadambaabadrakh@yahoo.com